



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 141

Улаанбаатар хот

Дуудлагын худалдаа зохион байгуулах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 2 нэрийн, нийт 128,350,000.00 (нэг зуун хорин найман сая гурван зуун тавин мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, хавсралтад заасны дагуу худалдах доод үнийг тогтоосугай.

2. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал Г.Ёндонд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай

2.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөллийг оролцуулан үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу үйлдвэрийн газрын дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
132004803
9-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн
171 дугаар тогтоолын хавсралт

**"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

Д/д	Суудлын автомашины нэр	Сери	Улсын дугаар	Үйлдвэрл эсэн он	Ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Худалдах доод үнэ
						(төгрөг)	
1	Ниссан Икс-трайл	ОРХ	06-07	2008	2014	70,850,000	5,000,000.00
2	Ниссан Икс-трайл	ОРО	85-48	2012	2016	57,500,000	5,000,000.00
Нийт дүн						128,350,000.00	10,000,000.00
						(нэг зуун хорин найман сая гурван зуун тавин мянган)	(арван сая)